


- Монголчууд ямар өнгийг мөнхийн амьдрал, тайван амгаланг бэлгэддэг гэж үздэг вэ? Зөв хариуг сонгоно уу.
A. улаан B. шар C. хөх D. ногоон
- Өнөржин баяжихын эх, ариун сэтгэл, цэвэр цэмцгэр байдлыг илтгэдэг өнгийг сонгоно уу.
A. цагаан B. шар C. хөх D. ногоон
- Дулаан өнгүүд хоорондоо болон хүйтэн өнгүүд дотроо гэх мэтээр шүтэлцэн зохицох байрлалыг юу гэж тодорхойлдог вэ? Зөв хариуг сонгоно уу.
A. өнгө ялгарах B. өнгө харших C. өнгө хорших D. өнгө хиртэх
- Тогтвортой байдлыг илтгэдэг зураасны төрлийг сонгоно уу.
A. шулуун B. тахир C. долгионтой D. нуман
- Хөдөлгөөнтэй, догдлонгуй, аядуу байдал илэрхийлэх зураасны төрлийг сонгоно уу.
A. шулуун B. тахир C. долгион D. махир
- Зураасны таталтын хурд, даралтын хүнд хөнгөнөөс хамаарч зураасны шинж чанар илэрнэ. Тэгш хэмтэй, эмх цэгцтэй, зөөлөн сэтгэгдэл төрүүлэх зураасыг сонгоно уу.



A.



B.




C.



D.

- Зурагт үзүүлсэн өнгийн дагнаасыг ажиглаад, зөв хариуг сонгоно уу.



- түүхий дагнаас
- их дагнаас
- солонгон дагнаас
- туурган дагнаас

- Бидний эргэн тойронд харагдаж байгаа бодит юмсыг зургийн хавтгай дээр орон зайтай чигээр нь дүрслэн харуулах аргыг алслалтын арга гэдэг. Нэг цэгийн алслалтаар зурсан зургийг сонгоно уу.



A.



B.




C.



D.

9. Зураг үзүүлсэн биетүүдийг харааны түвшний хаана байршуулан зурсан байна вэ? Зөв хариуг сонгоно уу.



- A. харааны түвшний дээр
- B. харааны түвшний доор
- C. харааны түвшинд
- D. харааны түвшинд байршаагүй

10. Байгалийн зургаас алслалтын ямар төрлийг харж болж байна вэ? Зөв хариуг сонгоно уу.




- A. хоёр цэгийн алслалт
- B. дүрсийн алслалт
- C. өнгийн алслалт
- D. нэг цэгийн алслалт

11. Монгол зургийн ямар дагнаасын аргаар аяганы хэлбэр, орон зайг илэрхийлэх дарааллыг харуулсан байна вэ? Зөв хариуг сонгоно уу.



- A. түүхий дагнаас
- B. их дагнаас
- C. солонгон дагнаас
- D. туурган дагнаас

12. Зургийг ажиглаад нэг цэгийн алслалтын аргаар юмс (мод, зам)-ын байршил эзлэхүүнийг дүрслэх аргачлалыг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.



1. Хамгийн наана байгаа модны өндөрөөс болон замын өргөнөөс тус тус уулзалтын цэг рүү байгуулалтын шулуун зурна.
2. Харааны түвшний шулуун дээр уулзалтын цэгийг тэмдэглэнэ.
3. Байгуулалтын шулуунуудын тусламжтайгаар алслалтын зарчмаар наана байгаа юмс том, цаашлах тусмаа жижгэрч дүрслэгдэнэ.
4. Зургийн хавтгайд харааны түвшний шулууныг зурна.


A. 1-2-3-4

B. 2-1-3-4

C. 4-2-3-1

D. 4-2-1-3

13. Нэг цэгийн алслалтын аргаар биетийн эзлэхүүнийг дүрсэлсэн зургийг ажиглаад, биетүүдийн байршлыг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.



- A. В-биет харааны түвшинд, А болон Б биетүүд харааны түвшинд байршаагүй байна.
B. В-биет харааны түвшний цаана, А болон Б биетүүд харааны түвшинд байршиж байна.
C. А-биет харааны түвшний доор, Б-биет харааны түвшний дээр, В-биет харааны түвшинд байршиж байна.
D. А-биет харааны түвшний дээр, Б-биет харааны түвшний доор, В-биет харааны түвшинд байршиж байна.

14. Зураач Н.Адъяабазарын “Тэнгэрийн дагинас” бүтээлд голлон ашигласан өнгийн зохицлыг сонгоно уу.



- A. дулаан өнгийн зохицол
B. хүйтэн өнгийн зохицол
C. эрс, тэс өнгийн зохицол
D. уйтгартай өнгийн зохицол

15. Үсэг бол тодорхой тигтэй, гоо сайхны нарийн системтэй урлаг. Үсгийн хэв маягийг хэд ангилдаг вэ?

- A. 2 B. 3 C. 4 D. 5

16. Монголчууд шог хошин сэтгэлгээний баялаг уламжлалтай. Монгол шог хошин зургийн эх суурийг тавьсан зураачийг сонгоно уу.

- A. Ц.Байды B. Н.Оргил C. Б.Шарав D. Ц.Доржготов

17. Уран бүтээлийн утга санааг тодруулах, баяжуулах, дэмжих үүрэгтэй зохиомжийн дүрийг сонгоно уу.

- A. гол дүр B. туслах дүр C. гол ба туслах дүр D. зураач

18. Хээ угалз нь хүн төрөлхтний соёлын хөгжлийг дагалдаж ирсэн дүрслэх урлагийн хамгийн түгээмэл урлал юм. Монгол үндэсний хээ угалзын урлагийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан алдарт зураачийг сонгоно уу.

- A. О.Цэвэгжав B. Д.Манибадар C. Ү.Ядамсүрэн D. Г. Одон


19. Уран сайхнаар бичсэн үсгийг сонгоно уу.



A.



B.



C.




D.

20. Ардын гар урлалын бүтээл нь ард түмний дунд үүсэн бий болж, үеэс үед уламжлагдаж шинэчлэгдэн хөгжиж байдаг. Ардын гар урлалын төрөлд хамаарах бүтээлийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

21. Дүрслэх урлагийн төрлүүдээс уран зургийн бүтээлийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

22. Хээ угалз нь монголын ард түмний оюун санаа, олон үеийн хүсэл бодлыг илэрхийлсэн ардын урлаг соёлын чухал өв юм. Монголчуудын зохион бүтээсэн амьтны гаралтай хээ угалзыг сонгоно уу.



A.



B.



C.



D.

23. Шог хошин зураг нь зураасан зургийн төрөл бөгөөд сэдэв агуулгаас хамаарч гурван төрлөөр зурдаг. Шог хошин зургийн төрлүүдэд тохирох бүтээлийг зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

1. улс төрийн шог зураг

2. наргиа зураг

3. хошин хөрөг зураг



зураг. А



зураг. Б



зураг. В

A. 1-В, 2-А, 3-Б

B. 1-А, 2-Б, 3-В

C. 1-А, 2-В, 3-Б

D. 1-Б, 2-А, 3-В

24. Хүүхдийн зурсан уран зургийн дүр болон зохиомжийг зургийн үйл явдалтай харьцуулан ажиглаарай. Зургийн зохиомжийн гол дүрүүдийг харуулсан хэсгийг сонгоно уу.



2.2 дугаар зураг. Ц.Мөнхжин, нас 12. "Сүргээ хамгаалсан нь". 2008 он. Цаас, гуаш

Сүргийн манлай болсон хуц, ухна хоёр ижил сүрээ рүү нь дайрсан саарал чонотой сүргээ хамгаалан амь өрссөн тулалдаж буй үйл явдал. Хуц, ухна хоёрт нулимсаа гартал зөхөртлээ мөргүүлсэн чонын эмгэнэлт дүр. Мөн чононоос айн сандарч, хар хурдаар хуйлран давхисан хонин сүргийн эрчимт хөдөлгөөн. Доод хэсэгт үнхэлцгээ хагартал айж, нулимс асгаруулан зугтаж яваа ихэр хургаа дагуулан яваа эх хонь зэргийг дүрсэлжээ.



A.



B.



C.



D.

25. Монголчууд хээ угалзыг төрөл бүрийн материал дээр олон аргаар бүтээдэг баялаг уламжлалтай. Хээ угалзын зургийг нэртэй нь зөв зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

1. Цоолборлох аргаар давтамжтайгаар дүрслэн бүтээсэн амьтны дүрсийн гаралтай хээ угалз.
2. Ургамлын гаралтай давтамжтайгаар дүрслэн бүтээсэн цэцэг навчин хээ.
3. Давтамжтай дүрслэгдсэн усан хээ.
4. Геометр дүрсийн гаралтай давтамжтайгаар дүрслэн бүтээсэн алхан хээ.



A. 1-A, 2-C, 3-D, 4-B

C. 1-A, 2-C, 3-B, 4-D

B. 1-B, 2-C, 3-A, 4-D

D. 1-B, 2-C, 3-D, 4-A